

## **МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ХООРОНД ХУУЛЬ САХИУЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

О.Отгонтуяа

*Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны их сургуулийн  
Хувийн эрх зүйн тэнхмийн ахлах багш, цагдаагийн ахмад*

Монгол-Хятад хоёр улсын ард түмэн нь олон мянганьг элээсэн эртний хөршүүд бөгөөд түүхийн туршид улс төр, эдийн засаг, соёлын талаар өргөн харилцаатай явж ирсэн билээ. Монгол Улс, БНХАУ-ын хооронд 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоож, хоёр тал 1950 онд Улаанбаатар, Бээжин хотноо тус тус Элчин сайдын яамыг харилцан нээсэн. 1949-1962 онд хоёр талын харилцаа шинээр төлөвшин хөгжсөн бөгөөд энэ хугацаанд Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ (1960 он), Хилийн гэрээ (1962 он) зэрэг хоёр орны харилцааны эрх зүйн үндэс суурийг тавьсан олон гэрээ байгуулагдсан.

1994 онд Монгол Улс, БНХАУ-ын хооронд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг шинэчлэн байгуулсан. Энэхүү гэрээ нь хоёр улсын одоогийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Хоёр улсын Засгийн газрын хооронд 1955-2015 онд худалдаа эдийн засаг, төмөр зам, найрамдал, хамтын ажиллагаа, эрх зүйн туслалцаа, ялтан шилжүүлэх, хууль эрх зүй, боловсрол, зээл тусламж зэрэг чиглэлийн нийт 132 төрлийн гэрээ, хэлэлцээрийг байгуулсан боловч гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт төдийлөн хангалтгүй байна. Тиймээс гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээнүүдийг боловсронгуй болгох, нэгтгэх хэрэгцээ шаардлагыг судлах зорилгоор энэхүү илтгэлийг бичиж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын харилцаа эрс өргөжиж, хамтын чармайлт, харилцан ажиллагааг шаардсан асуудал олширч байгаагийн улмаас олон талын гэрээний эзлэх хувийн жин өсч, гүйцэтгэх үүргийн нь хүрээ өргөжин тэлж байна.

Тэгш эрхийн үндсэн дээр олон улсын эрх зүйгээр нийтээр зөвшөөрсөн зарчмын дагуу байгуулсан гэрээ олон улсын харилцааны түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Эдүгээ тэр нь улс гүрний хооронд улс төр, нийгмийн тогтолцооны ялгааг үл харгалзан найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийн харилцааг бүрэлдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой юм.

Олон улсын гэрээ нь анхлан Эртний дорно дахинд тэр дундаа Энэтхэг, Хятад, Египет зэрэг улсад үүсэн бүрэлдэж эхэлсэн бөгөөд эдүгээ мэдэгдэж байгаагаар манай эриний өмнөх /МЭӨ/ XIII зууны эхэнд байгуулагдаж эхэлжээ. Судлагдсан

гэрээний дотроос хамгийн эртнийх нь МЭӨ XIII зууны эхээр Египетийн фараон II Рамзес ба Хеттийн /Бага Азид байсан хаант улс/ хаан III Хаттусилийн хооронд байгуулсан гэрээ хэмээн эх сурвалжуудад дурджээ<sup>1</sup>.

Олон улсын гэрээ нь олон улсын эрх зүйн субъектүүд нийтлэг ашиг сонирхлынхоо асуудлаар олон улсын эрх зүйд нийцсэн бөгөөд заавал биелэгдэх эрх, үүрэг үүсгэсэн харилцаа тогтоох шийдвэрээ илтгэн нотолсон тохиролцоо бөгөөд талууд зохих эрх олж, үүрэг хүлээх зориг шийдвэрээ чөлөөтэй илэрхийлэн тохиролцсон байх нь олон улсын гэрээний эрх зүйн нэг гол шаардлага юм.

Олон талын гэрээнд оролцогч хүчирхэг гүрнүүд болон олонхийн ашиг сонирхлыг нийцүүлэн тусгах асуудал их ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, хүчний ба ашиг сонирхлын тэнцвэр гэрээнд нэгэн зэрэг тусгагдах нь тогтвортой байдлыг хадгалах нэг нөхцөл болж байна.

Олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2016 оны хуулийг баримтлан шийдвэрлэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 10.2-д “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, аравдугаар зүйлийн 10.3-д “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, аравдугаар зүйлийн 10.4-д “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.”, арван зургаадугаар зүйлийн 16.14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэсэн заалтууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний эрх зүйд хэрэглэхтэй холбогдсон гол үзэл баримтлал болох юм.

1921 оны 11 дүгээр сарын 03-нд байгуулсан Монгол-Оросын “гэрээ бичиг” нь тусгаар тогтносон Монгол Улсын анхны олон улсын гэрээ байсан бөгөөд Монгол Улс 1946 оны 6 дугаар сард НҮБ-ын гишүүнд элсэх өргөдлөө өгснөөр дэлхийн хамгийн түгээмэл гэрээний /НҮБ-ын Дүрмийн/ оролцогч нь болох үндэс суурийг өөрийн талаас тавьсан юм. 1961 онд гишүүн байх эрхээ эдэлснээс хойш НҮБ, түүний бараг бүх төрөлжсөн байгууллагатай хамтын ажиллагааны үндсэн гэрээ, хэлэлцээр байгуулжээ.

1962 онд БНМАУ /тэр үеийн/ Эдийн засгийн талаар Харилцан туслах зөвлөлийн гишүүнээр элссэн нь социалист орнуудтай явуулж байсан хоёр талын хамтын ажиллагааг олон талын харилцан ажиллагаатай хослуулах эрх зүйн нөхцлийг бүрдүүлсэн.

1990 оноос манай улсад болон социалист орнуудад нийгмийн байгууллын үндсэн өөрчлөлт гарснаас шалтгаалан хуучин найрамдал, хамтын ажиллагааны гэрээнүүдийг шинэчлэх шаардлагатай болсон бөгөөд сонирхогч орнуудтай энэ чиглэлийн шинэ гэрээ байгуулж байна. ОХУ-тай 1993 онд, БНХАУ-тай 1994 онд, Болгар улстай 1994 онд найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

---

1 М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр “Олон улсын эрх зүй” УБ., 1999 он

Үүнээс гадна, найрсаг харилцааны үндсийг тавьсан гэрээ хэлэлцээрийг Казахстан, Турк, Франц, Энэтхэг улстай байгуулсан. Хоёр талын харилцааны үндсэн чиглэлээр Холбооны Бүгд Найрамдах Герман Улстай 1994 онд, Их Британи ба Хойд Ирландын Нэгдсэн Вант улстай 1996 онд, Индонез улстай 1997 онд төр, засгийн тэргүүн, түүнчлэн гадаад хэргийн сайдын хэмжээнд гарын үсэг зурсан тунхаглалуудыг дээрх төрлийн гэрээтэй адилтган үзэж болох юм. Түүнчлэн Австрали, АНУ, Шинэ Зеланд, Япон улстай хамтран гаргасан мэдэгдлүүд нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны үндсэн зорилго, чиглэлийг тодорхойлсон юм.

Монгол Улс энх тайвныг бэхжүүлэх, зэвсэглэлийг хязгаарлах, зэвсэг хураах, хүний эрхийг дээдлэх, байгаль орчныг хамгаалан тэтгэх, олон улсын эрх зүйг дэлгэрүүлэн бэхжүүлэх зэрэг салбарт байгуулсан 70 орчим олон талт гэрээ, конвенцод нэгдэн оржээ.

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хооронд 1989 оны 8 дугаар сарын 31-ний өдөр БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ, 1991 оны 7 дугаар сарын 04-ний өдөр БНМАУ-ын ХЗЯ, БНХАУ-ын ХЗЯ хоорондын хамтран ажиллах тухай протоколыг байгуулсан.

Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын дипломат, консулын харилцааны, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн, олон улсын хүмүүнлэгийн, олон улсын аюулгүй байдлын, хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон 40 шахам олон талт гэрээ, конвенцыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна.

Монгол Улсын цагдаагийн байгууллагаас Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенц, Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамтай хэлэлцээр, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимтэй харилцан ойлголцлын санамж бичиг, БНХАУ-ын ӨМӨЗО-ы цагдаагийн ажил мэргэжлийн дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймгийн Шинэ барга хошууны Алтан эмээл хотын Дотоодыг хамгаалах товчоотой хамтын ажиллагааны хэлэлцээр зэргийг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үүнээс гадна, Монгол Улсын Цагдаагийн байгууллагаас БНХАУ-ын эрх бүхий байгууллагад “БНМАУ, БНХАУ-ын хооронд байгуулсан иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-ний дагуу сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 22 эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг илгээжээ. Үүнээс 2018-2020 онд илгээсэн 15 хүсэлтээс 8 хүсэлтийн хариуг тус улсаас ирүүлээгүй байна.

Мөн Монгол Улсын Дорноговь аймгийн Цагдаагийн газар болон БНХАУ-ын Эрээн хотын Цагдаагийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд тус цагдаагийн газраас сүүлийн 10 жилийн байдлаар 60 албан бичиг

явуулж, 6 албан бичгийн хариуг авч ажилласан байна<sup>1</sup>. Эдгээр тоо баримтаас хоёр улсын хооронд хамтран ажиллах санамж, бичиг, хэлэлцээрүүд байгуулагддаг боловч хэрэгжилт төдийлөн хангагддаггүй болох нь харагдаж байна.

Ийнхүү эрх зүйн үндэс хэдий бүрдсэн ч эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааны ажиллагааг хэрэгжүүлэхэд нэгтгэсэн хэлэлцээрийн дагуу шийдвэрлэх нь хүний эрх, эрх чөлөөг хангах, түүнийг хэрэгжүүлэхэд саад учрах нөхцөл байдлыг бууруулах ач холбогдолтой байж болох юм.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээр, хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилт төдийлөн хангагдахгүй байгаа шалтгааныг тодруулан авч үзвэл,

- “БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-ний дагуу тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурорын газраар уламжлуулан хүргүүлдэг боловч хүсэлтийг хүлээн авсан талаас хариу ирүүлдэггүй, улмаар хүндрэл гарч эрүүгийн хэргийг нотлох, шийдвэрлэх ажиллагаа удааширдаг.
- Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний 3 дугаар зүйлд эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн зохих төв байгууллагаар дамжуулан харилцаж байна гэж тусгасан ба харилцах төв байгууллага гэж “БНМАУ-ын Хууль зүй, арбитрын яам, БНМАУ-ын Дээд шүүх, БНХАУ-ын Шүүх яам, Ардын дээд шүүх”-ийг тус тус хэлнэ гэж заасан.
- Хоёр улсын Цагдаагийн байгууллагын хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд тодорхой ажиллагааг хийж гүйцэтгэж, шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авдаг боловч шүүхээс хэргийг хянан хэлэлцэх явцад тухайн нотлох баримтыг хуульд зааснаар Олон улсын гэрээнд заасны дагуу авч бэхжүүлээгүй гэсэн шалтгаанаар нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй зэрэг хүндрэл тулгарч байна.

### Дүгнэлт, санал:

Хоёр улсын Засгийн газрын түвшинд тодорхой гэрээ, хэлэлцээр, мөн яам, агентлаг, байгууллага хооронд гэрээ, санамж бичгүүд өргөн хүрээтэй байгуулагддаг боловч, хэрэгжилтэд хяналт тавих механизм, үр дүнг тооцох байдал нь төдийлөн хангалтгүй байна.

Улмаар эдгээр баримт бичгийг нэгтгэж, тодорхой чиглэлүүдээр /иргэний болон эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд шилжүүлэх, ялтан шилжүүлэх, харилцан мэдээлэл солилцох зэрэг/ бүлэгт хуваан харилцах, төв байгууллагыг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэг тус бүрт оноож өгөх, цаашид олон гэрээ, хэлэлцээр, санамж бичиг бус, нэгдсэн олон бүлэг бүхий /кодекс хэлбэрийн/ эрх зүйн баримт бичгийг байгуулж удирдлага болгон ажиллах

---

<sup>1</sup> Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл

шаардлага үүсч байна.

“БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-ний дагуу тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурорын газраар уламжлуулан хүргүүлдэг боловч хүсэлтийг хүлээн авсан талаас хариу ирүүлдэггүй хүндрэл гарч эрүүгийн хэргийг нотлох, шийдвэрлэх ажиллагаа удааширдаг бөгөөд тус гэрээний 3 дугаар зүйлд эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн зохих төв байгууллагаар дамжуулан харилцаж байна гэж тусгасан ба харилцах төв байгууллага гэж “БНМАУ-ын Хууль зүй, арбитрын яам, БНМАУ-ын Дээд шүүх, БНХАУ-ын Шүүх яам, Ардын дээд шүүх”-ийг тус тус хэлнэ гэж заасан нь учир дутагдалтай байна.

Мөн хоёр улсын Цагдаагийн байгууллагын хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд тодорхой ажиллагааг хийж гүйцэтгэн нотлох баримтыг гаргуулан авдаг боловч шүүхээс хэргийг хянан хэлэлцэх явцад тухайн нотлох баримтыг хуульд зааснаар Олон улсын гэрээнд заасны дагуу авч бэхжүүлээгүй гэсэн шалтгаанаар нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй зэрэг хүндрэл тулгарч байгаа нь цаашид хоёр улсын Засгийн газрын түвшинд байгуулсан гэрээ, хэлэлцээр, мөн яам, агентлаг, байгууллага хооронд байгуулсан гэрээ, санамж бичиг зэргийг нэгтгэж хууль хэрэгжүүлэх, сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааны хамтарсан хороо байгуулах хэрэгцээ шаардлагатай болжээ.

Тус хамтын хороог хоёр улсын Засгийн газар хооронд байгуулснаар хууль хэрэгжүүлэх, сахиулах байгууллагуудын хамтран ажиллах эрх зүйн орчин хангагдаж, гэмт хэргийн илрүүлэлт, тоо бүртгэл, статистикийн мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар тулгамдаж буй олон асуудал шийдвэрлэгдэх боломж бүрдэх юм.

**Ном зүй:**

Дипломат харилцааны тухай Венийн конвенц. 1961 он. Вена хот

Консулын харилцааны тухай Венийн конвенц. 1963 он. Вена хот

М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. “Олон Улсын эрх зүй” УБ.,1996 он

Б.Энх-Амгалан. “Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудал”  
эрдэм шинжилгээний өгүүлэл., УБ 2011 он

Ж.Соёлмаа. Монгол Улсын олон талт болон хоёр талт гэрээний өнөөгийн нөхцөл  
байдал, практик асуудлууд., УБ 2015 он

О.Үржин, Б.Эрдэнэчимэг нар Монгол, Хятадын түншлэл, хамтын ажиллагааны  
өөрчлөлт, шинэчлэл /эрх зүйн шинжилгээ/, УБ 2015 он

Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга/ Төрийн эмхэтгэл, 2017 он  
№02

Гадаад хэргийн яамны албан ёсны цахим хуудас <http://www.mfa.gov.mn/>

Монгол-Хятадын хоёр улсын түүхэн харилцааны он дараалсан лавлах /1949-2014/  
2014 он

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл. 2020 он

Гадаадын иргэн харьяатын газраас ирүүлсэн мэдээлэл. 2020 он